

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ: БҮРЭЛДЭХҮҮН, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ШИНЖЭЭЧ ТОМИЛОХ ҮЙЛ ЯВЦ, ДҮГНЭЛТ, ШИЙДВЭР, ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД

Уул уурхайн эрх зүй судлалын сан ТББ

СУДАЛГААНЫ ТОЙМ

Газрын хэвлийн баялгийг ашиглах буюу хатуу, цацраг идэвхт, хий, шингэн төлөв бүхий ашигт малтмалын хайгуул, ашиглалт, цаашлаад хаалтын үйл ажиллагаанд онцлог чиг үүргийг гүйцэтгэдэг, эрдэс баялгийн салбарын уламжлалт хийгээд орчин үеийн, мөн ирээдүйн институц хөгжлийн нэг хэсэг нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ) билээ.

ЭБМЗ нь Монгол Улсын Үндсэн хууль дах эрдэс баялагт холбогдох зарчмууд, түүнчлэн тус салбарын материаллаг хуулиуд дахь техникийн шинжтэй зохицуулалтуудын бодит хэрэгжилтийг хангах зохих шийдвэрийг гаргаж, ард иргэд, төрийн байгууллага, тус салбарт бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын дунд гүүр болж ажилладаг, үндэсний онцлог шинж чанар бүхий төрийн салбар байгууллага юм.

ЭБМЗ-ийн ил тод байдал нь хариуцлагатай уул

уурхайг хөхиүлэн дэмжих, цаашлаад эрдэс баялгийн салбарын тогтвортой, урт хугацааны хөгжлийг түүчээлэхэд голлох үүрэгтэй.

ЭБМЗ-ийн ил тод байдалд дотоодын эрх зүйн орчин, практик нөхцөлд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн уг судалгаа нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын олон улсын стандарт болон сонгосон улсын эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, түүнтэй адилтгах байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдлыг харьцуулан судалснаараа шинэлэг юм.

Зөвхөн ЭБМЗ гэлтгүй, эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг эрх зүйн зохицуулалт болон практикт ханган хөгжүүлэх нь Монгол Улсын Үндсэн хууль дах эрдэс баялгийн салбарт холбогдох зарчмууд, салбар эрх зүй, материаллаг хуулиуд, нийгэмд улам бүр биеллээ олох, цаашлаад бүс нутаг, олон улсад жишиг туршлага, судлагдахуун болох ач холбогдолтой юм.

СУДАЛГААНЫ БАГ:

Г.Сурахбаяр, Хууль зүйн докторант,
Г.Давааням, Хууль зүйн ухааны доктор,
Б.Оюунжаргал, Хууль зүйн ухааны доктор,

М.Дагва, Шинжлэх ухааны магистр,
Ч.Болормаа, Хууль зүйн магистр,
Э.Халиунгоо, Эрх зүйч.

АСУУДЛЫН ТОМЬЁОЛОЛ

ЭБМЗ-ийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалт, шинжээч томилох үйл явц, дүгнэлт, шийдвэр, хамаарал бүхий этгээдийг тодорхойлсон, нарийвчлан зохицуулсан, хуульчилсан зохицуулалт байхгүй, харин уг зөвлөлийн үйл ажиллагааг журамласан, эрх зүйн зохицуулалтын хэвшмэл арга хэлбэр үйлчилж байна.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэмд¹ зөвхөн бүрэлдэхүүний талаар ерөнхий тусгасан бөгөөд гишүүдийн тоо, ажиллах хугацаа, сонгон шалгаруулалт, томилгооны ил тод байдлыг тусгаагүй байна.

Мөн ЭБМЗ-ийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалт, шинжээч томилох үйл явц, дүгнэлт, шийдвэр, хамаарал бүхий этгээдийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (хуучин нэрээр), Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албаны цахим хуудсаар дамжуулан салбарын оролцогч талууд, иргэд, олон нийтэд байнга, тогтмол байдлаар мэдээлж, ил тод байдлыг хангаж буй тогтсон процедур байхгүй байна.

Дээр дурдсанаас гадна ЭБМЗ-ийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн (2021) 6.1.1 дэх “эрх бүхий мэдээлэл хариуцагч” гэж үзэж болно. Иймд тус зөвлөл нь тус хуулийн 8.1-ийн дагуу “...хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад бүх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах” үүрэгтэй. Гэвч ЭБМЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага нь тус зөвлөлийн хуралдаан, бүрэлдэхүүн, тэдгээрийг томилох, чөлөөлөх үйл явц, дүгнэлт, шийдвэр, хамаарал бүхий этгээд болон бусад мэдээлэл, бичиг баримтуудын ил тод байдлыг

зохиох ёсоор хангахгүй байгаа практик байна.

Аливаа байгууллага, зөвлөлийн ил тод байдлын бас нэгэн үзүүлэлт нь түүний бүрэлдэхүүний хараат бус байдал бөгөөд тэдгээр нь ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл нийтэд нээлттэй байх нь туйлын чухал, өөрөөр хэлбэл, Үндсэн хууль дах эрдэс баялгийн холбогдох зарчмын хийгээд тус салбарын тогтвортой хөгжлийн тулгуур нэгэн асуудал юм.

ЭБМЗ-ийн ил тод байдлын ач холбогдлыг тодотгохын тулд уг судалгаанд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

- ЭБМЗ-ийн ил тод байдлын талаарх дотоодын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх. Үүнд:
 - ЭБМЗ-ийн бүрэлдэхүүн, түүний сонгон шалгаруулалтын ил тод байдлын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх;
 - ЭБМЗ-ийн дүгнэлт, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх;
 - ЭБМЗ-ийн шинжээчийг томилох, түүний ил тод байдлын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх;
 - ЭБМЗ-ийн бүрэлдэхүүн, шинжээчийн хамаарал бүхий этгээдийн ил тод байдлын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх;
- ЭБМЗ-ийн ил тод байдлын талаарх суурь шалгуур болон олон улсын жишиг стандарт, туршлагыг шинэчлэн тодруулах;
- Дүгнэлт, зөвлөмж боловсруулах.

ЭБМЗ-ИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ЗОХИЦУУЛЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Манай улсын эрдэс баялгийн салбарын харилцааг Газрын хэвлийн тухай (1998), Ашигт малтмалын тухай (2006), Газрын тосны тухай (2014), Цөмийн энергийн тухай (2009) болон бусад ашигт малтмалын

төрлөөр ангилсан материаллаг хуулиудаар тус, тус зохицуулж байна.

Эрх зүйн анхдагч эх сурвалжийн хувьд “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого-2014-2025”

¹ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 27 -ны өдрийн А/195 дүгээр тушаал

(УИХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон)-д тус зөвлөлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилтыг дэвшүүлж байжээ.

ЭБМЗ-ийн үйл ажиллагаа буюу чиг үүргийг эдгээр хуулиудад, тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т “Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээч 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана” гэж заасан бөгөөд ЭБМЗ-ийн үйл ажиллагаа нь геологи, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг дараа, дараагийн шатанд гаргахад чухал оролцоотой нь үүнээс харагдаж байна.

Газрын тосны тухай хуулийн 23 дугаар зүйлд “гэрээлэгч нь баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх, улмаар төрийн захиргааны төв байгууллага нь тус зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн холбогдох төлөвлөгөөг батлах”-аар зохицуулжээ.

Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.5-т “Ашигт малтмалын тухай хуулийн 48.3 дахь хэсэгт заасны дагуу уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “...тухайн ордын нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг хавсаргана” гэж заасан байна.

Газрын хэвлийн тухай хуулийн 42 дугаар зүйл (Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих нөхцөл)-ийн 42.1-д “Барилга байгууламж барих талбайн газрын хэвлийд ашигт малтмал байхгүй тухай дүгнэлтийг геологийн байгууллагаас авалгүйгээр хот, суурин газар, үйлдвэрийн цогцолбор, барилга байгууламжийн зураг төсөл зохиох буюу тэдгээрийг барихыг

хориглоно”, мөн зүйлийн 42.2-т “Ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих, мөн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих зөвшөөрлийг гагцхүү онцгой тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Энэ тохиолдолд газрын хэвлийгээс ашигт малтмал олборлох боломжийг хангасан байвал зохино” гэсэн зохицуулалт, хэм хэмжээг ЭБМЗ-ийн чиг үүрэгт хамруулж үзэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, мөн хуулийн 10 дугаар зүйл (Газрын хэвлийг ашиглах зориулалт)-ийн 10.1 дэх “Газрын хэвлийг дор дурдсан зориулалтаар ашиглуулахаар олгох буюу 1) геологийн судалгаа хийх, 2) ашигт малтмал олборлохтой холбоотой үйл ажиллагаанд тус зөвлөлийн гүйцэтгэх чиг үүргийг өргөн агуулгаар тайлбарлаж, уялдуулж ойлгох нь зүйтэй.

Хуульчилсан актын хувьд “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм” (2021) болон “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам” (2012)-аар тус тус зохицуулж байна.

“Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”-д зааснаар тус зөвлөлийн чиг үүрэг нь хуралдааны үндсэн дээр дараах бичиг баримтуудын эрх зүйн болон практикийн нийцлийг ханган дүгнэлт, зөвлөмж боловсруулах юм. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөл, төсөв түүний жил бүрийн тодотгол, эцсийн үр дүнгийн тайлан,
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ордын нөөцийн тооцоо,
- Ашиглалтад бэлтгэгдсэн ордыг ашиглах ТЭЗҮ, уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө, баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ, тэдгээрийн тодотгол,

- Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ,
- Газрын тос, уламжлалт бус газрын тос (цаашид "газрын тос" гэнэ)-ны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ордын нөөцийн тооцоо,
- Газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын тос дамжуулах хоолойн ТЭЗҮ зэрэг багтана.

Мөн дүрэмд тус зөвлөлийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг зөвхөн “ хуралдааны үеэр хууль дээдлэх ёс, шударга ёс, хамтын удирдлагын зарчмыг

баримтлан цөөнхийн саналыг хүндэтгэн, олонхын саналаар асуудлыг шийдвэрлэж байх”-аар заасан байна.

Хэдийгээр ЭБМЗ-ийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалт, шинжээч томилох үйл явц, дүгнэлт, шийдвэр, хамаарал бүхий этгээд тэдгээрийн ил тод байдлын талаар тухайлсан зохицуулалтгүй боловч эрдэс баялгийн салбарын бусад материаллаг хуулиудад тусгагдсан зарчмыг баримтлан, захиргааны эрх зүй, түүний хэм хэмжээний актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг онцлог, хэлбэр бүхий зохицуулалтын дор үйл ажиллагаа явуулж байна гэж үзэж болохоор байна.

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ИЛ ТОД БАЙДЛЫН ШААРДЛАГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний **хэвлий**, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү **ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна**” хэмээн заасан бөгөөд мөн хуулийн Зургадугаар зүйлд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр “**Иргэн** эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар **мэдэх эрхтэй**” хэмээн эрдэс баялгийн салбарын холбогдох зарчмыг шинэтгэн нэмж тодорхойлсон болно.

Газрын хэвлийн тухай Монгол Улсын хууль (1988) нь “**өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд** нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино” гэж газрын хэвлийн баялгийн ашиглалтын үед “ард иргэд, салбарын оролцогч талуудын ашиг сонирхлыг” ямагт дээдлэх хавсарга зарчмыг мөн хуульчилжээ. ЭБМЗ нь Ашигт малтмалын тухай хууль (2006)-ийн 10.1.9-д² зааснаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгуулагдаж, Засгийн газрын

хэрэгжүүлэгч агентлаг “Ашигт малтмал газрын тосны газар”-ын дор харьяалагдан үйл ажиллагаа явуулдаг. Иймд яамд, засгийн газрын агентлагийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тус зөвлөл үйл ажиллагаандаа баримтлах учиртай.

Яамны эрх зүйн байдлын тухай (2004) хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Яам нь ... ил тод нээлттэй байх, ... зарчмыг баримтлан ажиллана”; Агентлагийн эрх зүйн байдлын тухай (2004) хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Агентлаг нь үйл ажиллагаандаа... хүртээмжтэй, **ил тод**, мэргэшсэн байх, зарчмыг баримтлан ажиллана” хэмээн заасан нь ЭБМЗ-ийн үйл ажиллагаанд ч мөн хамааралтай.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн (2021) 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” хэмээжээ.

² “Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлалыг батлах

Түүнчлэн салбарын гол хууль болон Ашигт Малтмалын тухай хуулийн 11.1.22-т “Төрийн захиргааны байгууллаганы сонирхсон этгээд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх чиг үүрэгтэй” талаар заасан байна. Ашигт малтмалын салбарын төрийн захиргааны байгууллага нь Ашигт малтмал газрын тосны газар бөгөөд АМТХ-ийн дагуу өөрийн харьяанд ажиллаж буй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хувьд төсөл хэрэгжүүлэгчийн зураг зүйн бүртгэлийн талаар нийтэд мэдээлэх үүргийг хүлээхээр хуульд заажээ.

Ийнхүү хуулиудад зохицуулснаас гадна хуульчилсан актуудад мөн тус зөвлөлийн үйл ажиллагааны **ил тод байдлыг хангахыг шаардсан** зохицуулалтууд бий.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-д (2022) заасанчлан “Мэдээллийг тухай бүр шинэчлэн, мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэхтэй холбогдох үүргийг эрх бүхий ажилтны албан тушаалын, эсхүл ажлын байрны тодорхойлолтод тусгах үүрэгтэй”.

Үүнээс үзвэл хэдийгээр ЭБМЗ-ийн үйл ажиллагааны үндсэн дүрэмд үйл ажиллагаандаа ил тод зарчмыг баримтлах талаар үгчлэн тусгаагүй ч Үндсэн хууль, материаллаг хуулиуд, захиргааны хэм хэмжээний актуудад зааснаар бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалт, шинжээч томилох үйл явц, дүгнэлт, шийдвэр, хамаарал бүхий этгээдийн талаар олон нийтэд ил тод байдлыг ханган ажиллах хууль зүйн шаардлагууд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын олон улсын стандарт

Эрдэс баялгийн салбарын олон улсын стандартаар ЭБМЗ-ийн ил тод байдлыг үнэлэх нь энэхүү судалгааны нэгэн шинэлэг тал юм. Байгалийн нөөцийн засаглалын институт³ээс эрдэс баялгийн салбарын ил тод байдлын шалгуурыг тодорхойлсон ба үүнд:

1. *Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (Extractive industry transparency initiative);*
2. *Нээлттэй засаглалын түншлэл (Open Government Partnership);*
3. *Байгалийн баялгийн тунхаг (Natural Resource Charter);*
4. *Нягтлан бодох бүртгэл, хөтлөлтийн ил тод байдал (Accounting standards) зэрэг стандартууд багтаж буй юм.*

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга болон **Нягтлан бодох бүртгэл, хөтлөлтийн ил тод байдлын стандарт** нь түлхүү эрдэс баялгийн салбарын олборлолт, түүний орлого зарлагын хэмжээ, хөтлөлтийг ил тод байлгахыг шаарддаг стандартууд бол **Нээлттэй засаглалын түншлэл** нь төрийн байгууллагуудын засаглалыг бэхжүүлэхийн тулд ил тод байдлыг дэмжих, иргэдийг чадавхжуулах⁴, хамтын ажиллагааг төлөвшүүлэх зорилготой. Монгол Улс Нээлттэй Засаглалын түншлэлийн Үндэсний IV ба V төлөвлөгөөний хүрээнд эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг тусгайлан хуульчлах үүрэг амлалт авсан болно.⁵

Харин **Байгалийн баялгийн тунхаг** нь засгийн газрууд, олон улсын хамтын нийгэмлэгт нөөц баялгийг хэрхэн оновчтой удирдах талаар чиглэл өгдөг бодлогын хувилбарууд, практик зөвлөгөөг багтаасан зарчмуудын цогц юм. Нөгөөтээгүүр *Байгалийн баялгийн тунхаг нь мэдээллийн ил тод*

³ Байгалийн нөөцийн засаглалын институт (Natural Resource Governance Institute) нь хөгжиж буй болон хөгжингүй орнуудын эрдэс баялгийн салбарын засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилладаг бодлогын чиг үүрэг бүхий ач холбогдолтой олон улсын байгууллага юм. <https://resourcegovernance.org/about-us>

⁴ Г.Сурахбаяр, Ч.Болормаа, Social License to Operate:

⁵ <https://www.opengovpartnership.org/members/mongolia/>

байдлыг шийдвэр гаргалтын процессын үндэс суурь болгохыг шаарддаг учир тус дүрмийн хүрээнд эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг үнэлж үзвэл:

1. Төсвийн ил тод байдал: Төсвийн нэн чухал баримт бичгүүд болох төсвийн тооцоолол, зарцуулалт, аудитын тайланг тухай бүр нийтлэх нь хариуцлагыг улам нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах нэг бүрдэл гэж үздэг.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хувьд үйл ажиллагааны дүрэмдээ олон нийтэд ил тод мэдээлэл хүргэх зорилго бүхий цахим хуудсыг ажиллуулахаар заасан хэдий ч тус цахим хуудаст ЭБМЗ-ийн төсвийн зарцуулалтын тайлан болон аудитын тайлангийн талаар мэдээлэл огт байхгүй байна.

2. Мэдээллийн хүртээмж: Олон нийтийн мэдээлэл авах эрх, Засгийн газрын мэдээлэлд нэвтрэх эрхийг баталгаажуулсан мэдээллийн хүртээмжийн тухай аливаа хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж байх нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэн чухал үзүүлэлт юм. Энэ үзүүлэлтийн хүрээнд мэдээлэл авах эрхийг Үндсэн хууль болон бусад суурь хуульдаа тусгаж өгсөн улс орнууд тус стандартыг хангаж буй гэж үздэг аж.

Манай улсын хувьд иргэний мэдээлэл авах эрхийг Үндсэн хуульдаа баталгаажуулж өгсөн бөгөөд мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан материаллаг хууль болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль ч мөн хүчин төгөлдөр үйлчилж байна. Түүнчлэн Яам, агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, ЭБМЗ-ийн дүрэм зэргээс үзвэл олон нийтэд мэдээлэл хүргэх талаар зохицуулалтууд туссан учир мэдээллийн хүртээмжийн суурь эрх зүйн шаардлагууд хангагдсан байна. Гэсэн хэдий ч бодит байдалд мэдээллийн хүртээмж хангалтгүй байгааг судалгааны бусад хэсэгт дэлгэрүүлэн судаллаа.

3. Төрийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг: Сонгогдсон болон бусад албан тушаалтны хөрөнгө, орлогыг олон нийтэд мэдээлэх журам нь авлигатай тэмцэх, нээлттэй, хариуцлагатай төрийг бэхжүүлэхэд зайлшгүй шаардлагатайгаас гадна эрдэс баялгийн салбарт олон нийтийн хяналтыг сайжруулах ач холбогдолтой.

Хэдийгээр Монгол Улсын хувьд төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудаст тухай бүр мэдээлдэг⁶ хэдий ч ЭБМЗ-ийн дарга болон бусад гишүүд, шинжээчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар тухайлсан мэдээлэл нийтэд ил тод бус байна. Хэдийгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам), Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын тодорхой хувь нь ЭБМЗ-ийг бүрдүүлж байгаа ч, тэдгээрийн хөрөнгө орлогын мэдүүлэг өнөөг хүртэл олон нийтэд ил тод бус хэвээр.

Байгалийн баялгийн тунхгийн шалгуурын хүрээнд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ил тод байдалд ерөнхий байдлаар дүн шинжилгээ хийж үзвэл төсвийн болон албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн ил тод байдлын шалгууруудыг бүрэн хангаагүй байна. Гэвч шалгуурууд бүрэн хангагдсанаар ил тод байдал хангагдсан гэж үзэх тул дээрх шалгуурын хүрээнд ЭБМЗ-ийн үйл ажиллагаа нь хаалттай хэмээн дүгнэж болохоор байна.

Үүнээс харвал төрийн байгууллагын (ЭБМЗ) үйл ажиллагааны ил тод байдлыг хангах дотоодын эрх зүйн зохицуулалт, олон нийтэд мэдээлэл хүргэх тухай журмуудад хуулиар хязгаарласнаас бусад үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээг олон нийтэд мэдэгдэж, тэдний мэдээлэл авах эрхийг хангах суурь зарчим тусгагджээ.

⁶ Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам"

Харин эрдэс баялгийн салбарын олон улсын жишиг баримт бичгүүдийн хүрээнд ил тод байдлыг үйл ажиллагааны төсөв, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй энгийн ойлгомжтой байдлаар хүргэж буй эсэх, тухайн зөвлөлийн албан тушаалтны

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Бусад улс орнуудад эрдэс баялгийн салбарын хөгжил болон төрийн байгууллын хэлбэрээс нь (холбооны болон нэгдмэл) шалтгаалан ЭБМЗ-тэй ижил чиг үүрэгтэй институт нь үндсэн хоёр хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Холбооны буюу мужийн тогтолцоотой улсын хувьд мужийн яам руу холбогдох саналыг хүргүүлдэг эрх бүхий байгууллага нь муж бүрд тусдаа байна. Харин нэгдмэл улсын хувьд нэгдсэн эрдэс баялгийн асуудал хариуцсан яамныхаа дор үйл ажиллагаа явуулж байна. Муж улсын тогтолцоотой улсаас Австрали, Канад, нэгдмэл тогтолцоо бүхий улсын хувьд Чили, Казакстан, Гана, Бразил зэрэг улсуудын эрдэс баялгийн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээ, чиг үүрэг төстэй байна. Эдгээр улсуудаас төлөөлөл болгон Австрали болон Гана улсыг сонгон, дэлгэрүүлэн судаллаа:

Австрали Улсын турилага:

Австрали улсын хувьд хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийг муж бүр бие даан олгож байна. Ийнхүү тусгай зөвшөөрөл олгохдоо **“Earth Resources Regulator”** хэмээх хяналтын институтээр хянагдан, холбогдох зөвлөмжийн хамт яаманд хүргэгдэж эцсийн шийдвэрийг гаргадгаараа онцлогтой.

Earth Resources Regulator нь дор дурдсан чиг үүргийг Ашигт малтмалын нөөцийн тухай (Тогтвортой хөгжил) 1990 он, Газрын тосны тухай (1998), Далайн газрын тос, хүлэмжийн хийг хадгалах тухай (2010), Газрын гүний дулааны эрчим хүчний нөөцийн тухай (2005) хуулиудын хүрээнд хэрэгжүүлдэг. Үүнд:

хөрөнгө орлогын мэдүүлэг ил тод байх байдлаар тодорхойлсон байна. Гэсэн хэдий ч эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдал нь дотоодын болон олон улсын стандартын шалгуурт бүрэн нийцээгүй болох нь харагдаж байна.

- Төрийн эзэмшилд байгаа ашигт малтмал, газрын тос, газрын гүний дулаан, олборлох нөөцөд нэвтрэх эрх олгох,
- Олон нийтийн аюулгүй байдал, газар нутаг, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалахад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу нөхөн сэргээлт, олон нийтийн оролцоо зэрэг хайгуул, уурхай, карьер, газрын тосны үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөний хүсэлтийг үнэлэн яам руу илгээх,
- Талбайн нөхөн сэргээлтийг үнэлэх, нөхөн сэргээлтийн бонд тогтоох,
- Операторын олон нийтийн аюулгүй байдал, байгаль орчны тогтвортой байдал, талбайн нөхөн сэргээлтийн стандартыг дагаж мөрдөхийн тулд сургалт, хяналт, хэрэгжилтийг хангах,
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад холбогдох төлбөрийг хураах.

Тус агентлагийн үйл ажиллагааг Оролцогч талуудын дүрэм (*Stakeholder engagement charter*)-ээр зохицуулдаг бөгөөд тус дүрмээр *Earth Resources Regulator* үйл ажиллагаандаа баримтлах зарчмуудыг тодорхойлсон⁷. Үүнд:

Зарчим 1: Ил тод, харууцлагатай байх

Тус зарчмын хүрээнд *Earth Resources Regulator* нь үйл ажиллагаа болон гаргасан шийдвэрийнхээ талаар оролцогч талуудад мэдээллийг тухай бүр өгөх бөгөөд оролцогч талуудыг ойлгоход туслах зорилгоор гол асуудлуудыг тайлбарлахын зэрэгцээ, ажиллах арга барилаа сайжруулахын тулд оролцогч талуудын саналыг тогтмол авч ажилладаг байна.

⁷ Coria, Jessica, and Thomas Sterner. "Natural Resource Management: Challenges and Policy Options." *Annual Review of Resource Economics*, vol. 3, 2011, pp. 203–30. JSTOR, <http://www.jstor.org/stable/43202696>. Accessed 14 July 2024.

Зарчим 2: Шударга байх

Энэхүү зарчмын хүрээнд өөрсдийн үйл ажиллагааны ажлын цар хүрээг оролцогч талуудад тайлбарлахын зэрэгцээ аливаа хүсэлтэд тухай бүр хариулт өгөх үүрэгтэйгээр ажилладаг байна.

Зарчим 3: Оролцогчдод нь ойлгомжтой, хүртээмжтэй, ойлгоход хялбар байдлаар мэдээллийг хүргэх

Энэхүү зарчим нь ил тод байдлыг хангах чухал зохицуулалт бөгөөд мэдээллийг энгийн байдлаар танилцуулж, юу хийж байгаа болон сонирхогч талууд хэрхэн оролцох талаар тоймлон харуулах үүрэгтэй байдаг. Тус үүргийн хүрээнд шинэчлэгдсэн мэдээлэл бүрийг энгийн англи хэл дээр, веб хуудсаараа дамжуулан хүргэхээр мөн заасан байна.

Ийнхүү зарчмын хүрээнд тус байгууллага нь гаргасан шийдвэрүүдийг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл дотроо уламжлалт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмал, ил уурхайн түүхий эд, эрдэнийн чулуу, газрын тос болон хий, газрын гүний дулааны эрчим хүч, нүүрс зэрэг ашигт малтмалын төрлүүдээр нь ангилан шийдвэрүүдийг нийтэлдэг. Ийнхүү нийтлэхдээ зөвхөн хүлээн авсан шийдвэрүүдийг нийтэлсэн байх бөгөөд хүсэлт гаргасан хуулийн этгээдийн мэдээллийг ч мөн дэлгэрэнгүй нийтэлсэн байна.

Түүнчлэн аливаа төслүүдэд зөвшөөрөл олгоход олон нийтийн зөвшилцөл, хууль эрх зүйн нийцэл зэрэг бүхий л шаардлагуудыг олон нийтэд ил болгосноороо онцлогтой. Гэсэн хэдий ч ямар хугацаанд хүсэлтийг шийдвэрлэх талаар дүрэмд заагаагүй байна.

Earth Resources Regulator нь гишүүд буюу зөвлөлийн ажилчдын мэдээллийг цахим хуудастаа ил тод нийтлээгүй байгаа хэдий ч холбогдох мэдээллийн албан тушаалтны мэдээллийг оруулсан байна. Мөн тус институт нь хагас жил бүрийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлдэг бөгөөд үүндээ төсвийн ил тод байдлыг мөн тусгадаг байна.

Түүнчлэн Австрали Улсын уул уурхайн үйл ажиллагаагаар тэргүүлэгч Квинсланд, Викториа тэргүүтэй мужуудын уул уурхайн зөвлөл нь шийдвэр гаргахдаа байгаль орчин болон уугуул иргэдийн эрх ашгийг хэрхэн хөндөж буй, байгаль орчныг хэрхэн нөхөн сэргээх талаар аж үйлдвэр эрхлэгчийн төлөвлөгөөг заавал харгалзан үздэг байна.

Өөрөөр хэлбэл тус төслийг хэлэлцэхдээ байгаль орчин болон олон нийтийн эрх ашиг хөндөгдөх тохиолдлыг заавал харгалзан үзэж, тус шалгалтыг шийдвэр гаргалтын нэг үе шат болгон авч үзэхээс гадна ТЭЗҮ-ийн байгаль орчин, олон нийтийн эрх ашгийг хөндөх хэсгийг нийтэд мэдээлэх тал дээр анхааран ажилладаг аж.

Гана Улсын туриллага:

Ашигт малтмалын комисс нь Гана Улсын ашигт малтмалын зохицуулалт, удирдлага, уул уурхайтай холбоотой бодлогыг зохицуулах, хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага юм. Ашигт малтмалын комиссын тухай (1993) хуулийн 450-р зүйлийн дагуу тус байгууллага нь ТУЗ-ын дарга, Гүйцэтгэх захирал, бусад гишүүдээс бүрдсэн нийт есөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Гана Улсын Ерөнхийлөгч ашигт малтмалын комиссын гишүүдийг Ашигт малтмалын комиссын тухай хуулийн 450-р зүйлийн 3 болон 4-т зааснаар “Комиссын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй хамааралтай мэдлэг, туршлага болон хуульд заасан бусад нөхцөл”-ийг харгалзан гурван жилийн хугацаатайгаар сонгох бол гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн даргыг Ерөнхийлөгч салбарын сайдтай зөвшилцсөний үндсэн дээр сонгоно. Гүйцэтгэх захирал нь комиссын гишүүний нэгэн адил зөвлөлийн гишүүн бөгөөд комиссын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах, бусад захиргааны ажилчдыг удирдлагаар хангах үүргийг хүлээдэг.⁸

Ашигт малтмалын комиссын тухай хуулийн 450-р зүйлд комиссын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

⁸ Ашигт малтмалын Комиссын тухай хууль Mineral Commission act,1993 <https://www.mincom.gov.gh/wp-content/uploads/2022/03/Minerals-Commission-Act-1993-Act-450-1.pdf>

- Үндэсний эдийн засгийг зохих ёсоор харгалзан үзэж, эрдэс баялгийн салбарын тэргүүлэх чиглэлийг тогтооход туслах, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үндэсний бодлогын зөвлөмжийг боловсруулах,
- Ашигт малтмалтай холбоотой асуудлаар Газар, байгалийн нөөцийн сайдад зөвлөгөө өгөх,
- Төрөөс ашигт малтмалын талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, энэ талаар сайдад мэдээлэх,
- Ашигт малтмалын асуудал эрхэлсэн бүх байгууллагын ажиллагаанд хяналт тавьж, сайдад тайлагнах,
- Ашигт малтмалтай холбоотой олон нийтийн гэрээг хүлээн авч үнэлэлт дүгнэлт өгөх, УИХ-д тайлагнах,
- Үндэсний хэмжээний шийдвэр гаргахад үндэсний ашигт малтмалын нөөц, хайгуул, ашиглалтын технологийн талаарх иж бүрэн мэдээлэл цуглуулах баттай суурийг бий болгох.

Дээрх чиг үүргүүдийн хүрээнд Комисс нь 2012 оны Ашигт малтмал, уул уурхайн (тусгай зөвшөөрөл) журмын 174-ын 1 болон 2-т заасны дагуу ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн өргөдлийг хянах бөгөөд хуульд заасан үндэслэлүүд болон Комиссын удирдамжид нийцсэн техник, эдийн засгийн үндэслэл зэргийг харгалзан өргөдлийг хүлээн авах эсэхийг үнэлж, шийднэ.⁹ Ашигт малтмал, уул уурхайн (тусгай зөвшөөрөл) журмын 174 дүгээр зүйлд нийцсэн өргөдлийг бүртгэж, хүлээгдэж буй өргөдлийн тухай мэдэгдлийг 15 хоногийн дотор нийтэд мэдээлнэ. Ийнхүү нийтлэгдсэнээс хойш комисс 30 хоногийн дотор тус журмын 178 дугаар зүйлд заасны дагуу Газар, байгалийн нөөцийн сайдад тухайн өргөдөл гаргагчийн хүсэлтийг хүлээн авах эсэх талаар зөвлөмжийг хүргүүлж, энэхүү зөвлөмжийг харгалзан сайд 21 хоногийн

дотор татгалзах, эсвэл ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг олгох тухай шийдвэрийг өргөдөл гаргагчид сайдын нэрийн өмнөөс хүсэлтээс татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрлийг олгосон тухай мэдээлнэ.¹⁰

Гана Улсын энэхүү байгууллага нь ЭБМЗ-өөс чиг үүргийн хувьд төсөөтэй боловч Засгийн газраас гэрээгээр эрх шилжүүлэн авч, Газар, байгалийн нөөцийн сайдын өмнө хариуцлага хүлээдэг байна. Энэхүү комисстой холбоотой үйл ажиллагаа нь тус байгууллагын цахим хуудсанд нээлттэйгээр байна. Үүнд:

- **Комисст ажиллаж буй гишүүдийн нэр, тэдний туршлага, холбогдох мэдээлэл:** Гана Улсын хувьд Ашигт малтмалын комисс нь комиссын гишүүдийн мэдээллийг цахим хуудастаа ил тод нийтэлсэн (<https://www.mincom.gov.gh/the-board/>) байхаас гадна дотоод захиргааны ажилчид, тэдгээрийн үйл ажиллагааны бүтцийг мөн нийтэлсэн байна.
- **Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн өргөдлүүд болон тэдгээрийн шийдвэр:** Өргөдлүүдийг хэзээ илгээсэн, ямар байгууллага ашигт малтмалын ямар төрөлд хүсэлт илгээсэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар ил тод байна. Өөрөөр хэлбэл, MCAS систем буюу Уул уурхайн кадастрын удирдлагын системээр дамжуулан Комисст ирсэн нийт өргөдөл, үүнийг хүлээн авч тусгай зөвшөөрөл олгосон мэдээлэл болон бусад кадастр, зураг, өргөдлийн үйл явцын талаарх мэдээллийг¹¹ оруулсан байна.
- **Уул уурхайн салбарын статистик мэдээлэл:** Гана Улс нь Австрали Улсын мөн адил үйл ажиллагааны тайлан болон төсвийн тайлан, статистик мэдээллийг жил бүр нийтэлдэг байна.

Мөн Гана Улсын Ашигт малтмалын комиссын үйл ажиллагааны онцлог зүйл нь тусгай зөвшөөрлийн

⁹ Buur, Lars, Malin J. Nystrand, and Rasmus Hundsbojk Pedersen. "The political economy of land and natural resource investments in africa: an analytical framework." Danish Institute for International Studies, 2017. <http://www.jstor.org/stable/resrep13422>.

¹⁰ Ашигт малтмал, уул уурхайн (тусгай зөвшөөрөл) журам <https://www.mincom.gov.gh/wp-content/uploads/2021/06/Minerals-and-Mining-Licensing-Regulations-2012-L.-I.-2176.pdf>

¹¹ 2024 оны 7 сарын 4-нд хандалт хийв. <https://ghana.revenue.gov.gh/tender>

эрх авсан аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулдаг бөгөөд тус гэрээнүүдийг цахим хуудастаа бүрэн эхээр байршуулжээ.

Дэлгэрүүлэн судалсан дээрх 2 улсаас гадна Португаль, Польш, Швед, Финлянд, Унгар, Канадын Бритиш Колумб болон Онтарио мужууд эрдэс баялгийн салбарт манай мэргэжлийн зөвлөлийн адил тусгай зөвшөөрөл эзэмшигч болон салбарын яамдын дунд чухал үүрэг бүхий консул, зөвлөлийг

ЗӨВЛӨЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний сонгон шалгаруулалтын ил тод байдал:

ЭБМЗ нь дарга, орлогч дарга, салбар хуралдааны дарга, нарийн бичгийн дарга гишүүдээс бүрдэх бөгөөд эрдэс баялгийн асуудал эрхэлсэн сайд тус бүрэлдэхүүнийг томилохоор дүрэмд¹² заасан байна. Ийнхүү томилохдоо гишүүдэд тухайн чиглэлээр (эрдэс баялгийн салбарын) 10-аас доошгүй жилийн туршлагатай, түүгээрээ мэргэшсэн байх бөгөөд тал хувь нь ТББ-ын төлөөлөл, тодорхой хэсэг нь төрийн албан хаагч байх шаардлагыг заажээ. Үүнээс үзвэл эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус институтийн оролцоог тэгш хангахыг зорьсон нь харагдаж байна.

Гэвч ЭБМЗ (<https://mpc.mmhi.gov.mn/>), Ашигт малтмал газрын тосны газар (<https://www.mrpm.gov.mn/>), Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны (<https://mmhi.gov.mn/>) цахим хуудаст дүн шинжилгээ

ажиллуулж буй туршлага байна. Тэдгээрийн нийтлэг жишиг нь олон нийтэд хэлэлцэж буй төслийн цар хүрээг заавал мэдээлж, тухайн төслийг хэзээ хүлээн авч хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг тухай бүр хүргэхийн зэрэгцээ, байгаль орчин болон уугуул иргэд (олон нийт)-ийн оролцоог цахим (шууд) болон төлөөллийн байдлаар хангаж буйгаараа онцлог байна.

хийж үзэхэд тус зөвлөлийн бүрэлдэхүүний талаар мэдээлэл байхгүй байна.

Үндэсний геологийн алба (<https://ngs.gov.mn/4404-2/>)-ны цахим хуудаст Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2022.05.09-ний өдрийн А/93 тушаалын 2 дугаар хавсралтаар “Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны бүрэлдэхүүн”¹³-ийг баталсан тушаалын хуулбарыг 2022 онд 1 удаа нийтэлснээс өөр бусад салбар хуралдаан, тэдгээрийн бүрэлдэхүүний талаар мэдээлэл олон нийтэд огт мэдээлээгүй.

Энэ нь тус зөвлөлийн гишүүн болон шинжээч нарын бүрэлдэхүүн нь ЭБМЗ-ийн дүрмийн 10 дугаар зүйлд заасан шаардлагуудыг бүрэн хангадаг эсэхэд салбарын оролцогч талууд, иргэд, олон нийтэд эргэлзээ төрүүлэхээс гадна оролцогч талуудад мэдээлэл дутмаг буйг харуулж байна.

¹² Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм (2021)-ийн 10 дугаар зүйлийн 10.1 болон 1Е.2 дахь хэсэг 10.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах шаардлага хангасан тохиолдолд томилно.

¹³ <https://ngs.gov.mn/4404-2/>

Шигтгээ 1

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 20 албан хаагч ТУЗ-ийн гишүүнээр, 12 албан хаагч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр, 1 албан хаагч “Эрдэнэс Монгол” компанийн болон Хөгжлийн банкны ТУЗ-ийн гишүүнээр тус бүр ажилладаг...

...Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг нэр дэвшигчдээс сонгон шалгаруулалгүй, шууд томилох эрх зүйн зохицуулалтыг эргэж нягтлах, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-д авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өөрчлөлт оруулах, ажлын үр дүнг тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх...

АТГ-аас Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмж, 2022

Шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал:

ЭБМЗ-ийн дүрмийн 6.1 дэх хэсэгт “Зөвлөлийн хуралдаан нь хуралдааны бэлтгэл хангах, хуралдаанаар асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах гэсэн үе шатаас бүрдэнэ” гэжээ. Тус үе шатуудын ил тод байдал, олон нийтийн оролцоог хангаж буй нөхцөлийг судлан үзвэл:

Бэлтгэл үе шат

Хуралдааны бэлтгэл үе шатанд ил тод байдлыг хангах суурь зохицуулалт нь дүрмийн 7.3-т заасан “Салбар хуралдааны нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг 7 хоногийн дотор Зөвлөлийн дарга болон салбар хуралдааны даргад урьдчилан танилцуулж, хэлэлцэх асуудал, тэдгээрийн дараалал, хуралдаан болох өдөр, цагийг товлож, хуралдаан эхлэхээс өмнө 5 хоногт багтаан нийтэд цахимаар мэдээлнэ” гэх зохицуулалт юм.

Цахимаар мэдээлж буй байдлыг авч үзвэл тогтсон нэг цахим хуудсаар мэдээлэл хүргэдэггүй буюу Ашигт малтмал газрын тосны газар, Үндэсний геологийн алба болон Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн цахим хуудасны аль нэгээр нь тогтмол бус мэдээлдэг нь зөвлөлийн үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэрэгсэл тогтворгүй байгааг харуулж байна. Үндэсний геологийн албаны цахим хуудсанд геологи, хайгуулын судалгааны тайлан

хэлэлцэх ЭБМЗ-ийн хуралдааны зарыг тухайн аж ахуйн нэгж, төслийн нэр, төслийн ахлагч, шинжээчийн нэр зэргийг оролцуулан 2023, 2024 онд нийт 5 удаа нийтэлжээ.¹⁴ Харин ЭБМЗ-ийн цахим хуудсанд нийтлэгдсэн хурлын товгыг үзвэл 2022 онд 9, 2023 онд 13, 2024 онд 5 хурлыг тус, тус товлосноос харахад бэлтгэл үе шатны мэдээлэл бүрэн нийтлэгддэггүй гэж үзэж болохоор байна.

Тэрчлэн салбар хуралдааны бүрэлдэхүүн, шинжээч, тэдгээрийн хараат бус байдал, мэргэжил, мэргэшлийн талаар мэдээлэл байхгүй байгаа нь олон нийтийн мэдээлэл авах эрх, ил тод байдлыг хангахгүй байгаагийн илрэл хэмээн үзэж болох юм.

Асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах үе шат

ЭБМЗ-ийн тайлан хүлээн авч хэлэлцэх үе шат нь 1. Шинжээч томилох, 2. Хяналтын хуудас, 3. Хуралдаан, 4. Дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэргээс бүрддэг. Сүүлийн 2 жил буюу 2022-2024¹⁵ оны хооронд Үндэсний геологийн алба, Ашигт малтмал газрын тосны газар, ЭБМЗ-ийн цахим хуудсанд нийт 125 хүсэлтийг хүлээн авсан талаар нийтэлсэн байх бөгөөд эдгээр хүсэлтээс 27-д нь хурал товлосон хэдий ч хурлаар юуг, хэрхэн хэлэлцсэн, тодорхой шийдвэр гарсан эсэх талаар мэдээлэл байхгүй байна.

¹⁴ Хамгийн сүүлийн байдлаар 2024.06.05-ны өдөр хэлэлцэх хурлын зарыг 2024 оны 05 сарын 29-ний өдөр нийтэлжээ. <https://ngs.gov.mn/%d0%bc%d1%8d%d0%b4%d1%8d%d1%8d/page/2/>

¹⁵ 2022 оноос өмнөх мэдээлэл цахим хуудсуудад нийтлэгдээгүй байна.

Хүснэгт 1. ЭБМЗ-ийн веб хуудсанд ил тодоор мэдээлсэн товлогдсон хурлын тоо

Он	Ашигт малтмал ашиглалт		Боловсруулах үйлдвэр		Улсын төсвийн тайлан	Нийт товлогдсон
	ТЭЗҮ-салбар хуралдаан	ТЭЗҮ-өргөтгөсөн	ТЭЗҮ-салбар хуралдаан	ТЭЗҮ-өргөтгөсөн		
2022	6	2	1	0	0	9
2023	2	1	8	2	0	13
2024	0	0	3	0	2	5

Хүснэгт 2. ЭБМЗ-ийн веб хуудсанд ил тодоор мэдээлсэн товлогдсон хурлын дэгд бүртгэлтэй хүсэлтүүд

Он	Ашигт малтмал ашиглалт		Боловсруулах үйлдвэр		Улсын төсвийн тайлан	Нийт хэлэлцсэн хүсэлт
	ТЭЗҮ-салбар хуралдаан	ТЭЗҮ-өргөтгөсөн	ТЭЗҮ-салбар хуралдаан	ТЭЗҮ-өргөтгөсөн		
2022	82	2	1	0	0	85
2023	13	1	12	2	0	28
2024	0	0	4	0	8	12

Дээрхээс үзвэл ЭБМЗ-ийн сүүлийн 2 жилийн хугацаанд хүлээн авсан 125 хүсэлтийн 27-д нь хурал товлогдсон байна. Хурлын дэгт ороогүй үндэслэл, хурлын дэгт орсон хэдий ч хурал болсон эсэх, хурлаар хэлэлцэгдсэн эсэх, хэрхэн шийдвэрлэсэн талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй байна.

Түүнээс гадна ЭБМЗ-ийн хуралдааны дэг, тухайн хуралд томилогдсон шинжээч, шинжээчдийн бүрэлдэхүүн, холбогдох бусад этгээдийн оролцоог хангасан эсэх талаар мэдээлэл байхгүй байна. ЭБМЗ-ийн үйл ажиллагааны хамгийн ач холбогдол бүхий үе шат нь дүгнэлт, зөвлөмж боловсруулах бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.-т тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нууцлахаар хүсэлт гаргаагүй тохиолдолд боловсруулсан хайгуулын тайлан, уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэл зэргийг сонирхсон этгээдэд ил тод байхаар заасан байна.

Өөрөөр хэлбэл Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс тухайн төслийн талаарх мэдээллийг нууцлахаар гэрээ байгуулсан эсэх талаар ерөнхий мэдээллийг олон нийтэд мэдээлэх, нууцлахаар гэрээ байгуулаагүй төслийн тухайд хүсэлт гаргасан сонирхогч этгээд танилцах боломжтой байхаар

зохио арга хэмжээг авах нь зүйтэй. Өмнөх хэсэгт дурдсанчлан манай ЭБМЗ-ийн үйл ажиллагаатай төстэй үйл ажиллагаа явуулдаг Гана Улсын Ашигт малтмалын комиссын хувьд төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан гэрээг олон нийтэд цахим хувилбараар дэлгэсэн туршлагыг энд жишээ болгон дурдаж болох юм.

Хуульд нийцүүлэн, төсөл хэрэгжүүлэгч болон төрийн захиргааны байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн ТЭЗҮ-тэй танилцах боломжоор сонирхогч этгээд, төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдийг хангах, цаашлаад төсөл хэрэгжүүлэгч ТЭЗҮ-ийн зөвхөн тодорхой хэсгийг нууцад хамааруулахаар заасан бол нууцад хамаараагүй үлдсэн хэсэг (зардал, үр ашгийн тооцоо, байгаль орчин, орон нутгийн харилцаа ба хөгжил, ажлын байр, нийгмийн хариуцлага гэх мэт асуудлууд, түүнд зарцуулах төсөв гэх мэт)-ийн мэдээллийг ил тод болгох бүрэн боломжтой талаар хуульд заажээ.

Гэтэл өнөөг хүртэл дээр дурдсан нууцад хамааруулаагүй ТЭЗҮ болон ТЭЗҮ-ийн холбогдох хэсэг, зөвлөлийн хуралдаанаас олон нийтэд гаргаж буй дүгнэлтийн танилцуулга, тус дүгнэлтээр

байгаль орчин болон олон нийтийн эрх ашигт хамаарал бүхий асуудал, санал тусгагдсан эсэх, шинжээчийн дүгнэлтийн ерөнхий утга зэрэг нууцад

үл хамаарах, иргэний Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрхийг хангаж буй практик байхгүй байна.

Шинжээч томилох үйл явц, түүний ил тод байдал

ТЭЗҮ-ийн журамд¹⁶ шинжээч гэж “геологи, уул уурхайн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай инженер, салбарын доктор, профессор цолтон, тухайн мэргэжлээр мэргэшсэн болон Монгол Улсын зөвлөх инженерийг хэлнэ” хэмээн тодорхойлсон. ЭБМЗ-ийн дүрэмд “ёс зүйн зөрчилгүй, салбарын мэргэшсэн хүн байх” гэсэн

ерөнхий шаардлагыг тавьсан бөгөөд орд ашиглах, баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г Ашигт малтмал, газрын тосны газраас ЭБМЗ-д хүргүүлсний дараа, зөвлөлийн дарга мэргэжлийн дүгнэлт гаргах шинжээч болон шинжээчдийн хэсгийг тухайн асуудал хариуцсан салбар хуралдааны даргын саналыг үндэслэн томилохоор зохицуулжээ.

Шигтгээ 2

.....Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчид сайдын тушаалаар зөвлөлийн гишүүн, шинжээчийн үүргийг давхар гүйцэтгэж байна. Тус яамны холбогдох албан тушаалтнууд нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дарга, гишүүдээр давхар ажиллаж, УИХ-ын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27 дугаар тогтоолд заасан 16 орд буюу бусад ордтой холбоотой асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, төсөв хөрөнгийг батлах, нөөцийг тогтоох, хяналт шалгалт явуулах үйл ажиллагаанд шинжээчээр томилогдох буюу ажлын хэсэгт орж ажиллахдаа цалингаас гадуур нэмэлт хөлс авч байна.....

Авлигатай тэмцэх газрын төрийн албаны албан тушаалын байдалд хийсэн дүн шинжилгээнээс, 2021

Шинжээч нь ТЭЗҮ-д хийсэн өөрийн шүүмж, дүгнэлтийн үнэн бодит байдлыг хариуцахаас гадна, орд ашиглах болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г боловсруулсан аж ахуйн нэгжийн мэргэжлийн ур чадвар, гүйцэтгэлийн чанарын талаар үнэлгээ өгч, Зөвлөлд санал оруулах эрхтэй онцгой чиг үүрэг бүхий субъект юм. Шинжээчийн эрх, үүрэг, хариуцлага болон урамшууллын асуудлыг ТЭЗҮ-ийн журам болон Зөвлөлийн дүрэмд нарийвчлан тусгасан байх боловч зарим заалтууд давхардаж, эрх зүйн зөрчил үүссэн байна. Тухайлбал ТЭЗҮ-ийн

журамд шинжээчид нарийн тоочин тодорхойлсон шалгуур тавьсан бол ЭБМЗ-ийн дүрэмд ерөнхий шаардлага тавьсан нь эрх зүйн давхардлыг үүсгэж байгаа бол, төрийн албан (төрийн захиргааны албан хаагчаас бусад) хаагч шинжээч хийж болохоор заасан нь чиг үүргийн давхардлыг үүсгэж байна.

Чиг үүрэг болон эрх зүйн зохицуулалтын давхардлаас гадна зөвлөлийн гишүүн, шинжээчээр давхар ажиллаж буй практик байгаа нь зөвлөлийн ил тод, хараат бус байдалд эргэлзээ төрүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

¹⁶ Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074 дүгээр тушаалын хавсралт “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам

ЭБМЗ-ийн гишүүн, шинжээчийн хамаарал бүхий этгээдийн ил тод байдал

Судалгааны өмнөх хэсгүүдэд ЭБМЗ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам)-ны агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын дор үйл ажиллагаа явуулдаг талаар дурдсан билээ. Иймд тус зөвлөлийн үйл ажиллагаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай (2012), Авлигын эсрэг хууль (2006)-д нийцсэн байх учиртай.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүний даргын хувьд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дах хэсэгт заасанчлан “төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан”, гишүүдийн хувьд мөн хуулийн 4.1.5 дах хэсэг заасан “улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан”, 4.1.8 дэх “эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан”-д тус тус багтаж байна. Харин ЭБМЗ-ийн дүрмээр шинжээч нь төрийн захиргааны албан хаагчаас бусад ямар ч этгээд томилогдож болохоор заасан.

Ийнхүү ЭБМЗ-ийн дарга, гишүүд, шинжээчид Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээд тул үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой, өмнө нь хамтран ажиллаж байсан этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохыг хориглосон.

Манай улсын ЭБМЗ-ийн шинжээчийн хувьд төсөл хэрэгжүүлэгч нь ашиг сонирхлын зөрчилтэй болон хамаарал бүхий этгээд учир дүгнэлт гаргахаас татгалзсан тохиолдол гарсан эсэх талаар олон нийтэд ил тод бус байна.

Мөн ЭБМЗ нь Авлигын эсрэг хуулийн хүрээнд төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх, гаргасан шийдвэрээ иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байлгах үүрэг хүлээсэн. Гэтэл удирдлага, бүрэлдэхүүн, салбар зөвлөл, шинжээчийн мэдээлэл олон нийтэд ил тод бус байгаа нь зөвлөл үйл ажиллагаагаа хараат бус явуулж буй эсэхэд тавих олон нийтийн хяналтад хаалт тавьж буй нэгэн хэлбэр билээ.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ЭБМЗ нь эрдэс баялгийн салбарын голлох үүрэг бүхий төрийн институтын нэг болох нь зөвлөлийн шийдвэрийн чиг үүрэг, шийдвэр гаргалтад эзлэх байр сууриас харагдаж байна. Харин тус зөвлөлийн үйл ажиллагаа, бүрэлдэхүүн, түүний хамаарал бүхий этгээд, томилгооны нөхцөл байдлыг олон улсын стандарт болон дотоодын эрх зүйн зохицуулалттай уялдуулан судалж үзвэл олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэрэгсэл тодорхой

ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны хүрээнд ЭБМЗ-ийн үйл ажиллагаа (бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалт, шинжээч томилох үйл явц, дүгнэлт, шийдвэр, хамаарал бүхий этгээд)-ны ил тод байдлыг сайжруулах үүднээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Салбарын материаллаг голлох хуулиудад¹⁷ Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн чиг үүргийг тодорхой тусгахын зэрэгцээ үйл ажиллагаандаа баримтлах зарчмууд, тэр дундаа ил тод байх зарчим, түүний хэрэгжилтийг хангах механизмыг нарийвчлан тусгах;
2. ЭБМЗ-ийн бүрэлдэхүүн буюу гишүүдийг тоо, томилогдох хугацааг тус зөвлөлийн дүрэмд нарийвчлан тусгах;
3. ЭБМЗ-ийн дүрэм болон ТЭЗҮ хүлээн авах журамд шинжээчид тавигдах шаардлагыг хоёр өөр байдлаар зохицуулсныг нэгдмэл болгож, шинжээчийн мэргэжил, мэргэшил, ашиг сонирхлын зөрчилгүй байдлыг олон нийтэд ил тод байлгах суурь зохицуулалтыг ЭБМЗ-ийн дүрэмд тусгах;

Мэдээллийн ил тод байдлыг хангах практикийн хүрээнд:

1. ЭБМЗ-ийн бүрэлдэхүүний мэдээллийг олон нийтэд ил тод болгох: ЭБМЗ-ийн бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албан ёсны цахим хуудаст байршуулж, бүрэлдэхүүний гишүүн бусад удирдлагын ажлын туршлага (мэргэшил болон өмнөх ажлын туршлага, эрдэс баялгийн салбар

бус, хуулиар хүлээсэн нууцад хамаарахаас бусад мэдээллийн ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар нээлттэй болгох шаардлага хангагдахгүй байна. Зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах сайн туршлагыг эрэлхийлж бусад улсуудтай харьцуулан судалж үзвэл ашигт малтмалын зөвлөлүүд нь ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэл хүргэхэд илүү үр дүнтэй арга хэрэгслийг ашиглаж байгааг онцлон тэмдэглэлээ.

дахь хувь эзэмшлийн мэдээллийг мөн нийтлэх нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлнэ), болон аль салбар зөвлөлийн хуралдааны гишүүн болохыг тусгах;

2. Мэргэжлийн зөвлөл хүсэлтийг хэзээ хүлээн авсан, хурлын тов болон хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухай бүр мэдээлэх. Ийнхүү мэдээлэхдээ өөр, өөр байгууллагын цахим хуудаст бүрэн бус мэдээлэл нийтэлж буй жишгийг халж, тус зөвлөлийн цахим хуудсанд нэг дор мэдээллийг төвлөрүүлэх нь олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах бодит хэлбэр болно;
3. Шинжээчийн мэдээлэл, ялангуяа томилгооны мэдээллийг ил тод болгох нь олон нийтийн хяналт бий болгож, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх, олон нийт түүнд тавих хяналтыг сайжруулах ач холбогдолтой. Түүнчлэн шинжээчийн хувьд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хувийн харилцаа, ашиг сонирхлын зөрчил бий эсэх, хамаарал бүхий этгээдийн харилцаа байхгүй талаар мэдэгдэл гаргаж болох юм. Энэ нь нэгэнт шинжээчийн нэр олон нийтэд ил тод болсноос гадна хурлаар хэлэлцэж буй төсөл хэрэгжүүлэгчийн хооронд ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил байхгүйг илтгэнэ;
4. ЭБМЗ нь төрийн албаны нэгэн салбар тул төсөв, санхүүгийн ил тод байдлыг мөн хангах шаардлагатай. Иймд үйл ажиллагааны төсөв, зарцуулалтын мэдээллийг нийтлэхээс гадна, гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах шаардлагыг хуульчлах нь зүйтэй.

¹⁷ Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай, ашигт малтмалын төрлүүдээс хамааран зохицуулдаг хуулиуд болох Газрын тосны тухай, Цөмийн энергийн тухай хуулиудад

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, хуульчилсан акт

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Газрын хэвлийн тухай хууль, 1988
- Ашигт малтмалын тухай хууль, 2006
- Газрын тосны тухай хууль, 2014
- Авлигын эсрэг хууль, 2006
- Цөмийн энергийн тухай хууль, 2009
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, 2012
- Газрын тосны тухай хууль, 2014
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль, 2004
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 201 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны А/245 тоот тушаалын Хавсралт: "Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм"
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайдын 2012 оны 74 тоот тушаалын хавсралтаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн Техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"

Гадаад эх сурвалж

- Buur, Lars, Malin J. Nystrand, and Rasmus Hundsbojk Pedersen. "The political economy of land and natural resource investments in africa: an analytical framework." Danish Institute for International Studies, 2017. <http://www.jstor.org/stable/resrepr13422>.
- Coria, Jessica, and Thomas Sterner. "Natural Resource Management: Challenges and Policy Options." Annual Review of Resource Economics, vol. 3, 2011, pp. 203–30. JSTOR, <http://www.jstor.org/stable/43202696>. Accessed 14 July 2024.

Цахим хуудас

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (<https://mmhi.gov.mn/>)
- Ашигт малтмал, газрын тосны газар (<https://www.mrgpm.gov.mn/>)
- Үндэсний Геологийн алба (<https://ngs.gov.mn/>)
- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (<https://mpc.mmhi.gov.mn/>)
- Канадын уул уурхай, металлурги, газрын тосны институт (https://www.cim.org/?gad_source=1&gclid=CjwKCAjw7s20BhBFEiwABVIMrfGDji8LbD6KpWKcy9AIOTCEDUYtwsG1oL7CFWP9a1k-jV7XRIDJXxoCaEcQAvD_BwE#)
- Австралийн Байгалийн Нөөцийн зохицуулах алба, Викториа муж (<https://resources.vic.gov.au/about-us/our-role/earth-resources-regulator>)
- Гана Улсын Ашигт малтмалын Комисс (<https://www.mincom.gov.gh/>)
- Казакстан Улсын уул уурхайн танхим (<https://chamberofmines.kz/en>)
- Чили Улсын уул уурхайн комисс (<https://consejominero.cl/en/home/>)

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Уул уурхайн эрх зүй судлалын сан (УУЭЗСС) нь Монгол Улсын эрдэс баялаг, хүрээлэн буй орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны онол, бодлого, практикийн судалгаа, сургалт, тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилготой, 2010 онд байгуулагдсан үндэсний төрийн бус байгууллага юм. Тус сан нь эрдэс баялгийн салбарын ил тод байдал, өрсөлдөх чадвар, уурхайн хаалт, уул уурхайн салбар дахь байгаль орчны менежмент, байгаль орчны үнэлгээ зэрэг цаг үе, хөгжлийн асуудлаар мэргэжлийн түвшинд анхаарал хандуулан ажилладаг төдийгүй хууль, уул уурхай, байгаль орчны салбарын академик байгууллага хоорондын уялдаа холбоо, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, тус салбар дахь эрх зүйч, залуу судлаачдыг дэмжин ажилладаг онцлогтой байгууллага юм.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар
хот-14240, Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Веб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

